

**Д.УРИАНХАЙН ЖҮЖГИЙН ЗОХИОЛ ДАХЬ
БЭЛГЭДЭЛ ШИНЖИЙГ ШИНЖЛЭХ НЬ**

Мөчир

Товч агуулга: Бэлгэдэл шинж чанарыг ихээр агуулдаг нь Д.Урианхайн жүжгийн зохиолын онцлог шинжийн нэгэн том илрэл юм. Энэхүү бэлгэдэл нь Д.Урианхайн жүжгийн зохиолын гарчиг ба жүжгийн баатрын нэр, санаа хийгээд дүр, үйл явдал дээр тус тус илэрч байдаг.

Түлхүүр үг: *Д.Урианхай, жүжгийн зохиол, бэлгэдэл шинж*

Монгол Улсын нэрт яруу найрагч, жүжгийн зохиолч Д.Урианхай нь XX зууны ерээд оноос жүжгийн зохиол оролдож, бичиж эхэлсэн бөгөөд богино хугацаанд цаг үеийн нөхцөл байдал, хүн зоны оюун бодлыг гүн ухааны сэтгэлгээгээр илэрхийлж, маш олон дорвитой бүтээл туурвижээ. Эдгээрийн дотроос “2-1=0 буюу харанхуйд харагдахгүй”, “Цонхоор харсан хүмүүн”, “Шөнө дөлөөр эзгүй хээр тааралдсан эр эм хоёр” зэрэг жүжгийн гурван зохиол нь бичлэгийн онцгой хэв маягаар түлхүүр бичсэн байдаг.

Бэлгэдлийн шинж чанарын онцлог гэдэг нь далд үзэл, гол утга болох гоо зүйн таашаалын зарчим хийгээд зайлшгүй хандлагыг агуулсан байдаг гэж эрдэмтэд үздэг. Бэлгэдэл зүйн үзэл бол өрнө дахины онцлог, утга зохиолын урсгал бүлгийн ууган урсгал бөгөөд бэлгэдлийг илэрхийлэх хэлбэр нь сүүлийн үеийн бусад үзэл, урсгал туурвилын хамгийн чухал арга барилын нэг болон ашиглагдсаар байгаа билээ. Тухайлбал, Д.Урианхайн жүжгийн зохиол нь шинэ агуулга бүхий бэлгэдлийн системийг бүрдүүлснээрээ онцлог гэж хэлж болно. Энэхүү бэлгэдэл шинж нь жүжгийн гарчиг ба жүжгийн баатрын нэрийн бэлгэдэл, санаа дүрийн бэлгэдэл, үйл явдлын бэлгэдэл зэргүүдэд түлхүүр илэрч байна.

Нэг. Нэрийн бэлгэдэл

Зохиолын баатрын нэр хийгээд зохиолын гарчигт бэлгэдэл зүйг оруулсан нь онцгой бөгөөд уран зохиолд байнгын хэрэглэгддэг бэлгэдлийн арга мөн билээ. Д.Урианхайн жүжгийн зохиолд өвөрмөц онцгой бэлгэдэлт шинжийг зохиолын баатрын нэр ба зохиолын гарчигт шингээн, сонгон хэрэглэж, улмаар зохиолын агуулга, утга сэдэвтээ ч мөн адил шингээсэн байна.

“Хэнчбиш, Бибиш” хэмээх нэрс бол “2-1=0 буюу Харанхуйд харагдахгүй” жүжгийн хоёр гол баатрын нэр болно. “Хэнчбиш”-ээр хүний махан биеийг төлөөлүүлсэн бол “Бибиш”-ээр хүний оюун санааг төлөөлүүлсэн юм. Зохиогч хүний гадаад илэрхийлэл буюу бие махбод хийгээд хүнийг хүн болгодог сэтгэл оюуныг хоёр хүн мэтээр салган ондоошуулсан өвөрмөц шийдэл, хий дүрийг бүтээхдээ (Галбаатар, 2008:82) яагаад нэгийг нь “Хэнчбиш”, нөгөөг нь “Бибиш” хэмээн нэрлэсний учир нь ил тодоор бэлгэдэл санаа агуулж буйд оршино.

Хүний эрүүл, бүтэн бие махбод нь нүд, чих, ам, хамар, толгой, гар, хөл зэрэг эрхтнүүдээс бүтдэг. Иймээс “Хэнчбиш”-ийг төлөөлж байгаа махан бие нь хүн бүхэн буюу “хэн ч” байж болох юм. Харин хүн хүний хоорондох жинхэнэ ялгааг харуулж, хүнийг хүн болгодог буюу хүнийг “би” болгодог гол зүйл нь оюун санаа, үзэл бодол, сэтгэл юм. Иймээс “Бибиш” нь хүний оюун санаагаар илрэх “өөр би” байх ёстой.

Тэгвэл жүжгийн баатрыг яагаад “Хэн ч”, “Би” биш харин “Хэнчбиш”, “Бибиш” гэж нэрлэсэн бэ?

Энэ нь жүжигт тусгагдаж байгаа зохиогчийн нийгэм ахуй, хүн чанарын тухай үзэл бодолтой холбоотой. Үнэн худал холилдсон харанхуй нийгэм дахь хүн чанар гээгдэж улмаар хүнийг хүн биш болгон “өөр би”-ийн үгүйсгэлийг бий болгож байгааг бэлгэдлээр харуулж байгаа юм. Энэ тухай Ш.Баттөр “Жүжгээр илэрхийлэгдэж буй хүн чанар, хүний мөс нь хүнийг хүн болгогч, улмаар бидний оршихуй билээ. Энэ мөн чанар нь олон хэлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд хэрвээ энэ илэрхийлэл байхгүй бол бол Хэн ч биш, юу ч биш болж харанхуйд харагдахгүй. Зохиол өөрийн гэсэн мөн чанаргүй бол агуулга хэлбэр утгаа алддаг” (2003:55) хэмээн зөв тайлал гаргажээ.

“2-1=0 буюу харанхуйд харагдахгүй” хэмээх жүжгийн гарчигт ч мөн гүн гүнзгий бэлгэдэл зүй, санаа агуулагдаж байгаа юм. “2-1=0” гэдэг нь хүн чанарын сүйрлээс шалтгаалсан хүний нийгмийн хий хоосон чанарын бэлгэдэл мөн. “2” нь жүжгийн гол баатар “Хэнчбиш”, “Бибиш”-ийг хэлж байна. Өөрөөр хэлбэл хүний бие махбод хийгээд оюун санааг бэлгэдсэн хоёр “хүн”-ийг хэлж байгаа юм. Харин “1” гэдэг нь “Бибиш” буюу хүний оюун санаа, хүн чанарыг өгүүлжээ. “0”-ээр хий хоосон, ямар ч утга учиргүй зүйлийг бэлгэдсэн байдаг. Иймээс “2-1=0” нь “хүн чанар = хоосон” гэх томъёолол болж болох юм. Хэрвээ хүн чанар буюу оюун санаагаа алдвал хүн нь хүн биш, хий хоосон зүйл болно гэсэн гүн ухааны үзэл санаагаа зохиогч иймэрхүү өвөрмөц онцгой тооны томъёоллын бэлгэдлээр тодотгон гаргаж чаджээ хэмээн үзэж байна. “Харанхуйд харагдахгүй” гэдэг нь мөн гүн гүнзгий бэлгэдлийг агуулжээ. Шөнө мэт харанхуй нийгэмд үнэн ёс, үнэнч сэтгэл, ариун хайр, итгэл, нөхөрлөл, хүн чанар гэх мэт оюун санааны үнэт зүйлсээ гэж алдсаар сүүдэр төдий болсон “хүн дүрст”-үүдэд дасан зохицож, өөрсдийн бузар муухай бүхнээ олж харахгүйгээр түнэр харанхуйд аж төрөн, оршин тогтнох болно гэсэн гүнзгий санааг зохиолын гарчгаар бэлгэдэж харуулжээ. Нийтэд нь тайлбарлавал “харанхуй” өнгө аяс бол бүхий л жүжгийн турш тусгагдаж байгаа нэг зүйлийн талаарх бэлгэдэл санаа болно. Д.Урианхай нь жүжгийн зохиолдоо шөнийн харанхуйгаар нийгмийн “харанхуй”-г бэлгэдэн үзүүлсэн байдаг.

“Цонхоор харсан хүмүүн” зохиол бол галзуугийн эмнэлэг дахь бие сэтгэлийн эмгэгтэй гоонь эрийн үйл явдлаар сэдэвлэсэн “Ганц хүний парадокс жүжиг” гэх тодотголтой богино жүжгийн гарчиг болно. Тэгэхдээ жүжгээ “Галзуугийн эмнэлэг дахь эрэмдэг хүн” буюу “Галзуу хүн” гэж нэрлэсэнгүй харин “Цонхоор харсан хүн” хэмээн гарчигласан нь нэн учиртай. Жүжигт гол баатар эмнэлгийн өрөөн дахь модон орон дээр батганатай тулалдаж суухдаа хааяа хааяа цонхоор гадагш харан, гаднах ертөнцийг ажиглана. Гудамжны чимээ шуугиан, хүмүүсийн яриа хөөрөө, машины дуу, рок хөгжим, төмрийн хяхнаан, илжигний орилоон, нохойн гаслаан, нууцлаг нүргээн ... энэ бүхэн цонхоор тасралгүй дотогш дуулдана. Тэгэхээр энэ “цонх” бол эмнэлгийн өрөө хийгээд гаднах ертөнц хоорондын нэвтрэлцэх цорын ганц “үүд” юм. Галзуугийн эмнэлэгт хэвтэн буй солиот хүн бол нийгэм ахуйн харанхуй, амьдралын эрээн бараанд нухлагдсан эрэмдэг зэрэмдэг хүний дүр юм. Харин “цонх”-оор “амьдралын ёроол” дахь эгэл доорд хүмүүсийн ертөнцийн хий хоосон худал хуурмагийг нэвтрлэн, нийгэм ахуйн мөн чанарыг олж харах “нүд”-ийг төлөөлүүлэн харуулжээ. Өөрөөр хэлбэл гол баатрын гадаад ертөнцтэй харилцаж байгаа цорын ганц суваг болсон “цонх” бол нийгэм хийгээд хүний амьдралын үнэн гэж бодон итгэж явдаг худал хуурмаг, утга учиргүйгээр дүүрсэн ертөнц юм гэдгийг ойлгуулах арга бөгөөд уншигчид тэрхүү “хүний нийгмийн утга учиргүй мэт залхаг амьдралын гүнд энэхүү “ухаарлын цонх”-оор дамжин нэвтэрч амьдралын нууц руу өнгийх явдал юм” (Галбаатар, 2008:97).

Хоёр. Утга санаа, дүрийн бэлгэдэл

Нэг буюу олон санаа бүхий дүрийн давтамжаар утга санаагаа олонтоо илэрхийлж буй бэлгэдэлт дүрийг бүтээж, түүгээрээ дүрийн тухайн биеэс давсан гүн гүнзгий утга санааг илтгэдэг нь Д.Урианхайн жүжгийн зохиол дахь бэлгэдэл зүйн арга ухааны бас нэгэн чухал

хэлбэр болно. С.Дулам “Монгол Бэлгэдэл Зүй” гэх номдоо “Бэлгэдэл бол өргөн утгаараа бүхий л тохиолддог хүчин зүйлд нь авч үзсэн дүр мөн бөгөөд шавхагдашгүй олон утга аяс, амьдлаг цогцос бүхий дохио мөн билээ. Иймд аливаа бэлгэдэл болгон дүр байдаг бөгөөд дүр болгон ямар нэг хэмжээгээр бэлгэдэл байдаг. Бэлгэдлийн бүтцэд биет дүр, цаад далд утга хоёр нь нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй нэгдэн оршдог” (2009:3) гэж бэлгэдэл зүйн үүднээс дүр хийгээд бэлгэдлийн харьцааг оновчтой тайлбарлажээ .

Д.Урианхайн “2-1=0 буюу харанхуйд харагдахгүй” жүжигт “гал”-аар, “цонхоор харсан хүн” жүжигт “салхи”-аар тус тус утга санаа бүхий дүр бүтээж бэлгэдлийн утга санаагаа гүнзгийрүүлсэн юм .

Салхи: “Цонхоор харсан хүмүүн” жүжигт “батганатай улирал ... салхитай өдөр ...”-өөр үйл явдлын орчин ахуй ба арын үзэгдэл болгосон байдаг. Жүжигт зохиолын баатрын үйл явдал, үзэл сэтгэлгээний хөгжил хувирлын эргэн тойронд салхитай орчныг олонтоо дүрслэн үзүүлсэн бөгөөд “салхилж” байгаа байдал нь улам илүү ширүүсдэг .

Нэг дахь удаа:

Гадаа салхи хүчтэй салхилна ...

Салхинд нэг сонин хийсэж ирээд модны мөчирт орооцолдоно ...

Сонины дүрс салхины аясаар, янз бүрээр хувиран өөрчлөгдөнө ...

Хоёр дахь удаа:

Гудамжинд салхи хүчтэй ширүүснэ ...

Шороо ширүүн нүүгэлтэнэ ...

Гурав дахь удаа :

Гадаа салхи дахиад ширүүснэ ...

Модны мөчирт орооцолдон тогтсон сонин хийсэн одно ...

Шороон шуурга тавина, сул шороо, тоос нүүгэлтэн тэнгэр газар нийлээд юу ч үзэгдэхгүй болно ...

Шороон шуурга босож, тэнгэр газар нийлээд юу ч үзэгдэхгүй болоход галзуугийн эмнэлгийн цонхоор гадагш харж суусан өнөөх эрэгтэй (ихэд гайхшрангуйгаар) ...юу ч алга ... мод ч ... байшингууд ч ... загас ч! бүгд алга! (шогшрон) худал байжээ! Цөм салхинаас л болж харагдаж байж!(гүнээ бодлогошронгуйгаар) салхи байгаа учраас л бүх юм харагдаад байсан юм байна!...” хэмээн бодол болов. Зохиогч ийнхүү зохилын баатрын сэтгэлийн хөдөлгөөнийг дүрслэлээр дамжуулан харуулж, өөрөө хэлбэл “салхи”-аар бэлгэдэн жинхэнэ утга санаагаа цухуйлгаж гаргасан ажээ.

Үнэндээ “салхи”-аар хүний нийгмийн байр суурийн ялгаа зөрүүг гарган харуулж, эрх мэдэл, эд хөрөнгө, дарлал мөлжлөг зэргийг бэлгэдэн үзүүлж байгаа хэрэг юм .

Мөн гол дүр (баяртайгаар толгой дохин) “Бүх юм салхи! Бүгд салхи! Өвчин ч салхи! (нэгийг хүчлэн бодно ...) хэрвээ салхи устгачихвал бүх юм устана! (инээнэ) бүх юм хоорондоо адилхан болно! (бодолхийлсэн хэсэг төвдсөнөө, зөвшөөрөнгүй толгой дохиж) салхийг устгачихъя! бушуухан буудчихъя!...” хэмээн өнөөх хүмүүн цонхны хаалт уруу буудна. Буун дуу замхрахтай зэрэгцэн салхи ч нам жим болдог. Тэгэхэд өнөөх ганц хөл, ганц гартай зэрэмдэг эр (гараа өргөн) хөөе ээ, батганаа хүлээ! Чи бид хоёр одоо адилхан болсон! Одоо бүх юм хоорондоо ав адилхан! Биднийг ялгаатай болгодог юмыг би сая устгачихсан! Хоёулаа одоо адилхан юм чинь адилхан цугтаа нисье! Хүлээ! Ганцаараа юм одоо ганц ч байхгүй !” хэмээн өрөөнд нисэх батганын хойноос “яг л шувуу мэт чөлөөтэй , эрх жаргалтай нисэж” эхэлдэг.

Энэхүү зохиолын баатрын хачин жигтэй сэтгэлгээ, сэтгэлийн хөдөлгөөн хийгээд санаанаас гадна зохилын төгсгөлд гүн гүнзгий бэлгэдлийн санаа агуулагдаж байдаг. Баян ядуу, хүчирхэг, буурай, эрхэм дээд хийгээд эгэл доордын зөрүүг бий болгож байгаа тэгш бус нийгмийн ёс дүрэм, эд мөнгө, эрх мэдлийн шунахайрал, дарлал мөлжилт зэргийг устгачихвал хүн бүгд адил тэгш болж, эрх чөлөөтэй, аз жаргалтай болно гэсэн бэлгэдэл санааг тодорхой ойлгож болно.

Энэ тухай Ш.Баттөр “Жүжигт нийгмийн амьдрал, давхарга хоорондын ялгааг батгана, хүн, салхины харьцаагаар харуулсан байна. Салхиар ялгаа гаргагч бүхнийг төлөөлүүлсэн ба ийнхүү эзэгнэгч хийгээд эрхшээгчгүй болгосноор бүх юм унаган төрхөмдөө шилжиж, нийгэмд журам, хүмүүнлэг оршихуй бий болж болохыг үзүүлжээ” (2003:56) хэмээн зөв оновчтой өгүүлсэн юм.

Гал: “Монголын уламжлалт соёлд гал нь энх мэнд, дулаан, өсөн бадрах, сэргэн мандлын бэлэг тэмдэг болно” (Цолмон, 2007:225). Харин Д.Урианхайн жүжгийн зохиолд гал нь өөрөөр илэрдэг. “2-1=0 буюу харанхуйд харагдахгүй” жүжиг дахь “гал”-ын тухай дүрслэлээс сийрүүлбэл:

Хэнчбиш: (архи балган, хэл нь ороолдон) тэнгэр бурхан ч нүдтэй юм аа. Ёстой цагаа олж цасаар буллаа. (тэнгэр өөд харан) Тэнгэрээс л ингэж ташуурдаж өгөхгүй бол Монголыг бүхэлд нь хуйхалж байгаа энэ улаан галаас газраас ургах юм үлдэхээсээ өнгөрлөө.

Бибиш: (суугаагаараа гуйван) Монголын “ооч сахал”-ыг хяруусалж орхилоо хөөрхий!... (архи балган) гэхдээ ургана!... Чи бид хоёр үзэхгүй ч, ядаж ... гадны жуулчид үзнэ.

Хэнчбиш: (толгой сэгсрэн, шогшрон) бүхэл бүтэн улс ингээд шатчих юм! (Балган)

Бибиш: (архи балган) нүдэнд харагдах юм шатаж байгаа болохоор л анзаарч харан бүгд халаглаж байна. Гэтэл харагдахгүй түймэр гарчхаад байхад хэн ч тоохгүй! Бүгд сохор! Хүмүүс бол газар дээрх “сохор номин” юм! (Босон, гуйван алхаж) харагдахгүй юм шатахыг гэгээтэйд ч харахгүй, харанхуйд ч харахгүй! (Хуруугаа гозойлгон хий чичилж) харагдах юм шатвал түймэр, аа харин харагдахгүй юм шатвал мөхөл! Юу ч үлдэхгүй, юу ч үлдэхгүй, хов хоосон!... (Яах гэж боссоныг бүү мэд, буцан гуйван сууснаа архинаас балган) хүний нүдэнд харагдахгүйгээр шатаж байхад юугаар унтраах вэ, хам аа?

Хэнчбиш : (архи балган) суусаар!... (мар мар хөхрөн) энэ муу уусан архи л бүх түймрийг унтраана!

Бибиш: (архи балган, толгойгоо гунигтайгаар санжуулан) үгүй, хам аа, галыг гал нь унтраана! Урдаас нь угтуулан гал тавьж цурманд оруулах хэрэгтэй! (Байж сууж эс чадах мэт дахиад л гуйвлан босож) даанч тэгж гал тавья гэхэд оч үсэргэх, ядаж бүтэн толгойтой ганц чүдэнзтэй ч хүн алга...

Жүжигт “Монголыг тужид нь хуйхалж байгаа энэ улаан гал”-аар юуг бэлгэдэв? “Харагдахгүйд нь харагдахгүй түймэр гарах” гэж юуг заав? Бас “галыг гал нь унтраана” гэж ямар санааг илтгэв? Эдгээр асуултад бүхий л зохиолд тусгасан утга санаанаас онцгой хариулт олж болно. Балар харанхуй нийгэм, амьдрал ахуйд хүний мөн чанар гээгдэн, Монголчуудын уугуул соёл заншил, амьдрал, сэтгэхүйн хэлбэр өөрчлөгдөн баларч байгаад санаа зовсны улмаас нийгэм ахуй, засаг төрийн доройтлыг шүүмжлэн илчлэх нь бүхий л жүжигт тодрон гарч ирсэн утга санааны хураангуйлал болно. Тэгэхээр энэхүү дүрслэгдсэн “улаан гал” нь жинхэнэ гал биш, харин бүхий л Монголын нийгэм даяар нөлөөлж буй хүн чанарын сүйрэл, нийгэм төрийн доройтлыг бэлгэдэж байгаа юм. Нэн тодруулбал Монгол соёл, зан заншил, Монголчуудын ертөнцийг үзэх үзэл, сэтгэхүйн хэлбэрийг үгүй хийн баллаж байгаа нийгмийн харанхуй нөхцөл байдал, гаж буруу үзэл суртал болно. “Харагдахгүйд нь харагдахгүй түймэр гарах” гэсэн нь үндэстэн угсаатны соёл, сэтгэлгээний балран доройтлыг харуулж байгаа юм. Нүдэнд харагдаж, үзэгдэж байгаа түймэр аймаар бус, харин хүн чанар, соёл иргэншилд гарсан “харагдахгүй түймэр” хамгийн аймшигтай. Тиймээс “Нүдэнд харагдан шатах нь түймэр, харагдахгүй шатах нь мөхөл” гэсэн утгыг агуулжээ. Соёл нь шатвал үндэстэн мөхнө, энэ бол үнэн ёс. Тэгвэл соёлын эсрэг гарсан мөхлийн галыг юугаар унтраах вэ гэвэл тэрхүү хүн чанар, уугуул соёл, сэтгэлгээг өөрчлөн хувиргаж байгаа нийгмийн харанхуй бүтэц, гаж буруу хэв маягийг үгүйсгэх хэрэгтэй. “Галыг галаар унтраах” арга нь энэ юм. “Урдаас нь гал тавьж цурамдах хэрэгтэй! Даанч оч үсэргэх, ядаж бүтэн толгойтой ганц чүдэнзтэй хүн алга юм даа!” хэмээн соёлоо аврах, үндэстнээ аврах, балар харанхуй нийгэм, засаг төрийн өмнөөс эсэргүүцэн босох хүн нэг ч байхгүйд харамсан гуньж байгаа зохиогчийн үзэл санаа илэрч байна.

Гурав. Үйл явдлын бэлгэдэл

Үхэл: Д.Урианхайн “2-1=0 буюу харанхуйд харагдахгүй” хэмээх жүжиг нь таван бүлгээс бүтсэн урт жүжиг юм. Жүжиг бүхэлдээ жүжгийн баатар Бибишийн үхэл амьдын солбицлын дундах үйл явдлаар өрнөж, үзэл санааны гүн утга руу шилжсэн байдаг. Бүлэг бүрийн төгсгөлд Хэнчбиш нь Бибишээ алж булшилдаг бөгөөд дараагийн бүлэг эхлэхэд Бибиш нь дахин амилж босож ирдэг. Удаах үхэл бүрээр хүний биед байдаг үнэн, хайр халамж, итгэл найдвар мэтийн хүн чанарын агуулга дахь элементүүд нэг нэгээр устаж байгааг бэлгэдэж харуулсан бол, дараах амилах үйл явцад бодит ахуй, харанхуйн дундах хүн чанарын хоосрол, сүйрэл нь түр зуурынх байж, дахин амиллаа олдог гэсэн зохиогчийн итгэл болон эрмэлзлийг зүйлчлэн үзүүлэх аж. Гэвч зохиогчийн энэ хүсэл эрмэлзэл нь Бибишийн эцсийн үхлээр, оршин амьдрах утга агуулгаа алдсан Хэнчбиштэй хамт “харанхуйд харагдахгүй” хий хоосон зүйл болж хоцорсон билээ.

“Жүжгийн төгсгөлд цааш алхах газаргүй болсон Хэнчбиш өөрийн сэтгэл оюуны төлөөлөл болсон Бибишээ үүрд алдсанаа “хүн алагдлаа” хэмээн цагдаад мэдүүлж, “би ямар ч иргэн биш, зүгээр л бүтээгдэхүүн ...” гэсэн үгэнд нь орчин үеийн нийгэм дахь хүн чанарын сүйрлийг зохиогч ёс зүйн үүднээс онцгой тодоор дүрслэн харуулж чадсан байна”

Дүгнэлт

Д.Урианхайн жүжгийн зохиол нь жүжгийн гарчиг, жүжгийн гол баатрын нэрсээс авхуулаад үйл явдал хүртлээ хурц тод бэлгэдлийн шинжтэй байдгаараа бичлэгийн онцлог хэв маяг нь тодорч байгаа юм. Энэ нь мөн түүний жүжгийн зохиолын онцлог шинжийн чухал илрэл бөгөөд Монгол уламжлалт жүжгийн зохиолын бичлэгийн арга зүй, хэлбэр хийцэд гарсан томоохон хувьсал төдийгүй Монголын утга зохиолын хөгжил шинэчлэлд чухал хувь нэмэр оруулсан билээ.

Номзүй

Урианхай Д. 2000. “2-1=0 буюу Харанхуйд харагдахгүй”. УБ.

Урианхай Д. 2002. *Цонхоор харсан хүмүүн*. УБ.

Урианхай Д. 2011. *Шөнө дөлөөр эзгүй хээр тааралдсан эр эм хоёр*. Дэлхийн утга зохиол.

Галбаатар Д. 2008. “Эрин цаг зохиолч жүжиг” С. Отгончимэг, Г. Дэлгэрзун нарын найруулсан “Театр судлал ба орчин үе”. УБ.

Баттөр Ш. 2003. *Монголын модернист уран зохиол*. УБ.

Дулам С. 2009. Сөөө, Туяа нар Уйгаржин Монгол бичигт буулгасан: *Монгол бэлгэдэл зүй*. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.

Цолмон Ц. 2007. *XX дугаар зууны сүүлчийн 20 жил дахь Монгол туужийн онцлог хэлбэр*. Өвөр Монголын Ардын хэвлэлийн Хороо.

Summary

D.Uriankhai, a well-known Mongolian poet and writer of dramatic composition, began to try and write Dramatic composition in the 1990s, and in a short period of time he created many significant works that reflect the current situation and the human mind in a philosophical way.

The fact that it contains a lot of symbolic features is a big manifestation of the uniqueness of D.Uriankhai's dramatic composition. This symbol is reflected in the title of D.Uriankhai's dramatic composition and in the name, idea, character and events of the dramatic composition's protagonist.

D.Uriankhai's dramatic composition is characterized by a sharp symbolism, from the title of the play and the names of the main characters of the play to the events. It is also an important manifestation of the uniqueness of his playwriting and a major evolution in the methodology and design of traditional Mongolian playwriting. He is also an important contributor to the development and reform of Mongolian literature.